

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12.	Шилэн дансны мэдээлэл	8
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БҮС НУТГИЙН ЛОЖИСТИКИЙН
ТӨВИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Д.ЭНХБААТАР
ТАНАА

2020.04.02 № 06/1004
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төслийн зохицуулагч Д.Энхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төслийн нэгжийн ажиллагсдын хөлсөөр ажиллах гэрээг сунгах, цалин хөлсийг олгохдоо Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журмыг дагаж мөрдөх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Э.Цэрэннадмид хариуцаж хэрэгжүүлэв.

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 16 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2011 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан байна. Төслийг хэрэгжүүлэхэд Азийн хөгжлийн банкны тусгай сангийн хөрөнгөөс 25,358,000 зээлжих тусгай эрхтэй тэнцэх 40,000.0 мянган ам.доллар, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 5,000.0 мянган ам.доллар, Монгол Улсын Засгийн газар 26,639.1 мянган ам.долларыг тус тус санхүүжүүлэхээр болжээ.

Төслийн зорилго:

Тус төслийн зорилго нь Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх, гадаадаас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлж үр ашгийг дээшлүүлэхэд оршино. Замын-Үүд боомтод үр ашигтай, өрсөлдөхүйц, найдвартай холимог тээврийн системийг хөгжүүлэх, ложистикийн төвийг байгуулах зорилготой.

Хүрэх үр дүн:

- Замын-Үүдэд авто замаас авто зам руу, авто замаас төмөр зам руу, төмөр замаас төмөр зам руу шилжүүлэн ачих чадвартай байгууламж байгуулах;
- Терминалын тоног төхөөрөмж болон үр ашигтай удирдлагын системийг худалдан авч, суурилуулах;
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын институцийн чадавхыг сайжруулах болон төсөл хэрэгжүүлэхэд удирдлагын дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээг тус тус ашиглана.

Төслийн үйл ажиллагаа:

Сангийн яам болон Азийн хөгжлийн банкны шийдвэрээр төсөл хэрэгжүүлэх хугацааг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Ложистикийн төвийг Замын-Үүд сумтай холбох 4.347 км авто замын барилга угсралтын ажлыг нэмэлт гэрээний дагуу эхлүүлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгсөн.
2. Ложистикийн төвийн 1.2 км нарийн царигийн төмөр замын барилга угсралтын ажлыг нэмэлт гэрээний дагуу гүйцэтгэн 2019 оны 12 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгсөн.
3. Ложистикийн төвийг ашиглалтанд хүлээн авах улсын комиссын дүгнэлтэд тусгагдсан зайлшгүй хийх шаардлагатай 92,991.0 ам долларын өртөгтэй гэрээ хийгдэж 77,991.00 ам.долларын өртөг бүхий ажил хийгдсэн. Нэмэлт ажлуудыг хийж гүйцэтгэхээр CW1-2015/40 гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төсөл Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт нийцсэн байна.

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн

үйл ажиллагаанд Ексел программ ашигладаг байна.

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны батлагдсан зардлын төсвийг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 12,441,684.0 мянган төгрөгөөс тооцон 248,833.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 255,285.2 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны төсвийн зардлын гүйцэтгэлээр материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,276,546.0 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, дуусаагүй барилга данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	171,738.6	18,531.1	(153,207.5)
Бараа материал	76.4	76.4	-
Үндсэн хөрөнгө	62,993.2	50,615.9	(12,377.3)
Дуусаагүй барилга	81,704,415.8	94,146,546.6	12,442,130.8
Нийт хөрөнгө	81,939,224.0	94,215,770.0	12,276,546.0
Засгийн газрын хувь оролцоо	3,886.4	3,886.4	-
Хуримтлагдсан үр дүн	81,935,337.6	94,211,883.6	12,276,546.0
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	81,939,224.0	94,215,770.0	12,276,546.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны төлбөр тооцоог мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлсэнтэй холбоотой байна. Төсөл хэрэгжүүлэх хугацаа дуусаж байгаа тул зээл, тусламжийн үлдэгдэл санхүүжилтийг татсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаар хуримтлагдсан элэгдлийн дүн өссөнөөс шалтгаалжээ.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл өссөн нь АХБ-аас барилга, тоног төхөөрөмжийн гэрээний төлбөрийг шууд төлбөрөөр гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 12,441,684.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 10,636,600.0 мянган төгрөгийг зээл, 1,805,084.0 мянган төгрөгийг буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Зээлийн санхүүжилтээр 10,736,562.4 мянган төгрөг, буцалтгүй тусламжаар 1,874,691.1 мянган төгрөг олгогдсон байна. Тайлант онд хүүгийн орлого 634.7 мянган төгрөг орсныг төсөвт төвлөрүүлсэн байна.

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл нь 2019 онд 12,111,684.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 330,000.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Урсгал зардалд 330,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 322,131.2 мянган төгрөгийг зарцуулж, 97.6 хувьтай байна.

Хөрөнгийн зардалд 12,111,684.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 12,442,130.8 мянган төгрөгийг зарцуулж, 330,446.8 мянган төгрөгөөр хэтэрсэн нь ажил гүйцэтгэх гэрээний дагуу төлбөр тооцоог АХБ-аас шууд төлбөрөөр гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл тодорхойлж, нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 611,168.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 578,583.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 32,584.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 2 асуудлаар нийт 578,583.7 мянган төгрөгийн алдааг залруулан тайлагнасан. Үүнд:

1. 2019 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийсэн тайлангийн эцсийн үлдэгдлээс 575,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна",
2. Тайлант онд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх худалдан авалт хийж 3,583.7 мянган төгрөгийн татвараас чөлөөлөх санхүүжилтийг бүртгэл тайландаа тусгаагүй нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 2.7.в-д "Засгийн газрын санхүүжилтэд гадаад зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдэж байгаа бараа,

материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гааль болон НӨАТ-ын татвараас чөлөөлөгдсөн дүнг оруулна" гэсэнтэй нийцээгүй байна.

Залруулагдаагүй 32,584.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татах асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 61 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт:

Залруулагдаагүй 32,584.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 248,833.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн зарцуулалт

3.1.1 Илрүүлэлт: Төмөр замын дохиолол холбооны инженерийн 2019 оны хөлсөөр ажиллах гэрээг сунгаагүй 32,584.4 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196-р тушаалаар батлагдсан журмын 12.1.6-д "төслийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний хэрэгжилтийг хянах, дүгнэх, гэрээг сунгах, цуцлах болон тухайн ажилтныг урамшуулах, хариуцлага тооцох талаар санал боловсруулах, асуудлыг ТУХ, Сангийн яаманд танилцуулах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл: Цалин хөлсийг үндэслэлгүй олгосон байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төслийг хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс Төсвийн тухай хуулийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэснийг баримтлан орон тоо, цалингийн төсөв, ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг хугацаанд нь шинэчлэн баталж мөрдүүлэх, цаашид алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төмөр замын дохиолол холбооны инженерийн ажлаас чөлөөлөгдөх тушаал 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөр дуусгавар болсон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	171,738,595.85	18,531,118.49
Жижиг мөнгөн сан	377.88	377.88
Валютын харилцах данс	149,595,800.01	3,462,440.45
Төрийн сангийн харилцах данс	22,142,417.96	15,068,300.16
БАРАА МАТЕРИАЛ	76,363.64	76,363.64
Хангамжийн материал	76,363.64	76,363.64
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	171,814,959.49	18,607,482.13
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө	62,993,234.07	50,615,899.77
Авто-тээврийн хэрэгсэл	116,073,300.00	116,073,300.00
Хуримтлагдсан элэгдэл	(55,856,982.48)	(67,464,312.48)
Машин, тоног төхөөрөмж	49,079,453.69	49,079,453.69
Хуримтлагдсан элэгдэл	(49,079,453.69)	(49,079,453.69)
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,700,042.98	7,700,042.98
Хуримтлагдсан элэгдэл	(4,923,126.43)	(5,693,130.73)
Дуусаагүй барилга байгууламж	81,704,415,842.61	94,146,546,665.63
Дуусаагүй барилга	81,704,415,842.61	94,146,546,665.63
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	81,767,409,076.68	94,197,162,565.40
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	81,939,224,036.17	94,215,770,047.53
ЭЗНИЙ ӨМЧ	-	-
Засгийн газрын хувь оролцоо	3,886,400.00	3,886,400.00
Хуримтлагдсан үр дүн	81,935,337,636.17	94,211,883,647.53
Өмнөх үеийн үр дүн	45,014,080,718.57	81,935,337,636.17
Тайлант үеийн үр дүн	36,921,256,917.60	12,276,546,011.36
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	81,939,224,036.17	94,215,770,047.53
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	81,939,224,036.17	94,215,770,047.53

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Татаас санхүүжилтийн орлого	37,244,076,214.58	12,614,837,204.64
Зээлийн санхүүжилтийн орлого	33,899,576,995.05	10,736,562,366.91
Тусламжийн санхүүжилтийн орлого	2,072,599,219.53	1,874,691,134.91
МУ-ын Засгийн газрын санхүүжилт	1,271,900,000.00	-
МУ-ын Засгийн газрын санхүүжилт-Татварын чөлөөлөлт	-	3,583,702.82
Бараа ажил үйлчилгээний орлого	112,651.48	634,682.27
Бусад орлого	112,651.48	634,682.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	37,244,188,866.06	12,615,471,886.91
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
Ажиллагчидтай холбоотой зардал	244,740,268.25	218,253,454.73
Цалин	244,740,268.25	218,253,454.73
Бусад бараа үйлчилгээний зардал	86,961,761.96	120,473,506.32
Бичиг хэргийн зардал	1,050,700.00	450,000.00
Тээвэр, шатахууны зардал	4,354,373.00	4,110,223.00
Шуудан, холбооны зардал	2,168,294.98	1,995,281.00
Дотоод албан томилолтын зардал	8,624,024.36	9,013,100.00
Төлбөр, хураамж, даатгалын зардал	283,920.00	177,000.00
Банкны үйлчилгээний хураамж	34,088.41	10,025.05
Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний зардал	9,960,000.00	32,705,099.45
Урсгал засварын зардал	5,448,454.18	427,555.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс		27,882,497.00
Зар сурталчилгааны зардал	927,272.73	709,090.73
Байрны түрээсийн зардал	40,600,000.00	24,414,400.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,377,334.30	12,377,334.30
Бусад зардал	1,133,300.00	6,201,900.79
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	331,702,030.21	338,726,961.05
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	36,912,486,835.85	12,276,744,925.86
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	10,512,875.93	1,365,866.44
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	10,512,875.93	1,365,866.44
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,742,794.18	1,564,780.94
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,742,794.18	1,564,780.94
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	36,921,256,917.60	12,276,546,011.36

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
Татаас санхүүжилтийн орлого	37,244,076,214.58	12,611,253,501.82
Зээлийн санхүүжилтийн орлого	33,899,576,995.05	10,736,562,366.91
Тусламжийн санхүүжилтийн орлого	2,072,599,219.53	1,874,691,134.91
МУ-ын Засгийн газрын санхүүжилт	1,271,900,000.00	-
Бараа ажил үйлчилгээний орлого	112,651.48	634,682.27
Бусад орлого	112,651.48	634,682.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	37,244,188,866.06	12,611,888,184.09
Ажиллагчидтай холбоотой зардал	244,740,268.25	218,253,454.73
Цалин	244,740,268.25	218,253,454.73
Бусад бараа үйлчилгээний зардал	74,584,427.66	104,512,469.20
Бичиг хэргийн зардал	1,050,700.00	450,000.00
Тээвэр, шатахууны зардал	4,354,373.00	4,110,223.00
Шуудан, холбооны зардал	2,168,294.98	1,995,281.00
Дотоод албан томилолтын зардал	8,624,024.36	9,013,100.00
Төлбөр, хураамж, даатгалын зардал	283,920.00	177,000.00
Банкны үйлчилгээний хураамж	34,088.41	10,025.05
Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний зардал	9,960,000.00	32,705,099.45
Урсгал засварын зардал	5,448,454.18	427,555.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	-	27,882,497.00
Зар сурталчилгааны зардал	927,272.73	709,090.73
Байрны түрээсийн зардал	40,600,000.00	24,414,400.00
Бусад зардал	1,133,300.00	2,618,197.97
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	319,324,695.91	322,765,923.93
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	36,924,864,170.15	12,289,122,260.16
Хөрөнгө оруулалтын зардал	(36,871,290,238.59)	(12,442,130,823.02)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(36,871,290,238.59)	(12,442,130,823.02)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз	8,770,081.75	(198,914.50)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	8,770,081.75	(198,914.50)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	62,344,013.31	(153,207,477.36)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,394,582.54	171,738,595.85
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	171,738,595.85	18,531,118.49

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,886,400.00	45,014,080,718.57	45,017,967,118.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-
Тайлант үеийн үр дүн		36,921,256,917.60	36,921,256,917.60
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,886,400.00	81,935,337,636.17	81,939,224,036.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-
Хөрөнгийн үнэлгээний өсөлт, бууралт			-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		12,276,546,011.36	12,276,546,011.36
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,886,400.00	94,211,883,647.53	94,215,770,047.53

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,441,684,000.00	12,764,262,064.68	(322,578,064.68)	102.6
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	330,000,000.00	322,131,241.66	7,868,758.34	97.6
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,000,000.00	322,131,241.66	7,878,783.39	97.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,200,000.00	422,400.00	21,777,600.00	1.9
Түрээсийн зардал	22,200,000.00	422,400.00	21,777,600.00	1.9
Хангамж, бараа материалын зардал	7,998,000.00	6,277,975.00	1,720,025.00	78.5
Бичиг хэргийн зардал	650,000.00	450,000.00	200,000.00	69.2
Тээвэр, шатахууны зардал	5,907,700.00	4,387,678.00	1,520,022.00	74.3
Шуудан холбооны зардал	1,440,300.00	1,440,297.00	3.00	100.0
Томилолт зочны зардал	9,013,100.00	9,013,100.00	0.00	100.0
Дотоод томилолтын зардал	9,013,100.00	9,013,100.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	290,788,900.00	306,417,766.66	(15,618,841.61)	105.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	290,788,900.00	306,407,741.61	(15,618,841.61)	105.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		10,025.05	(10,025.05)	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ	12,111,684,000.00	12,442,130,823.02	-	102.7
Барилга байгууламж	12,111,684,000.00	12,442,130,823.02		102.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,441,684,000.00	12,611,253,501.82	(169,569,501.82)	101.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-	-	-
Бусад орлого		-		
Эх үүсвэрээс санхүүжих	12,441,684,000.00	12,611,253,501.82	(169,569,501.82)	101.4
Зээлийн санхүүжилт	10,636,600,000.00	10,736,562,366.91	(99,962,366.91)	100.9
Буцалтгүй тусламжийн санхүүжилт	1,805,084,000.00	1,874,691,134.91	(69,607,134.91)	103.9
Тохируулгын дүн		(198,914.50)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	171,738,595.85		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,531,118.49		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
Байгууллагын тоо	1			
Ажиллагсдын тоо	6			
Удирдах ажилтан	1			
Гүйцэтгэх ажилтан	5			

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/23/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4.0	5	8	9
1	Төмөр замын дохиолол холбооны инженерийн 2019 оны хөлсөөр ажиллах гэрээг сунгаагүй, ажилд томилсон тушаал шийдвэргүй 32,584.4 мянган төгрөгийн цалин хөлс олгосон нь СС-ын 2015 оны 196-р тушаалаар батлагдсан журмын 12.1.6-д "төслийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний хэрэгжилтийг хянах, дүгнэх, гэрээг сунгах, цуцлах болон тухайн ажилтныг урамшуулах, хариуцлага тооцох талаар санал боловсруулах, асуудлыг ТУХ, Сангийн яаманд танилцуулах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.	32,584.4	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Д.Энхбаатар Б.Энхсансар
Нийт дүн		32,584.4			